



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хэрлэн сумын ерөнхий боловсролын лаборатори Хан-уул цогцолбор сургуулийн
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/46/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 70584207 Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НББ	Нягтлан бодох бүртгэл



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15





Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Дорнод аймаг дахь Хэрлэн сумын ерөнхий боловсролын лаборатори Хан-уул цогцолбор сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Г.Бүдтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймаг дахь Хэрлэн сумын ерөнхий боловсролын лаборатори Хан-уул цогцолбор сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймаг дахь Хэрлэн сумын ерөнхий боловсролын лаборатори Хан-уул цогцолбор сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 19-нөөс 2020 оны 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймаг дахь Хэрлэн сумын ерөнхий боловсролын лаборатори Хан-уул цогцолбор сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.



Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймаг дахь Хэрлэн сумын ерөнхий боловсролын лаборатори Хан-уул цогцолбор сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүүхэд бүрийг хөгжүүлэх”-д оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Дорнод аймаг дахь Хэрлэн сумын ерөнхий боловсролын лаборатори Хан-уул цогцолбор сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймаг дахь Хэрлэн сумын ерөнхий боловсролын лаборатори Хан-уул цогцолбор сургуулийн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Дорнод аймаг дахь Хэрлэн сумын ерөнхий боловсролын лаборатори Хан-уул цогцолбор сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорнод аймаг дахь Хэрлэн сумын ерөнхий боловсролын лаборатори Хан-уул цогцолбор сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 19 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,101,184.0 мянган төгрөгөөс тооцон 42,023.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 45,894.9 мянган төгрөгөөр тооцсон нь тайлант онд санхүүжилт өссөнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорнод аймаг дахь Хэрлэн сумын ерөнхий боловсролын лаборатори Хан-уул цогцолбор сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50,338.9 мянган төгрөгөөр буюу 0,7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	181,056.0	285,440.6	104,384.6
Үндсэн хөрөнгө	7,575,288.8	7,670,775.3	95,486.5
Хуримтлагдсан элэгдэл	-408,682.5	-558,214.8	-149,532.3
Нийт хөрөнгө	7,347,662.3	7,398,001.2	50,338.9
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,347,662.3	7,398,001.2	50,338.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,347,662.3	7,398,001.2	50,338.9

Авлага дансны үлдэгдэл өссөн /буурсан асуудал байхгүй.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь номын фондыг үндсэн хөрөнгийн данснаас бараа материалын дансанд шилжүүлснээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд 49,444.8 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал /номын фонд/, 3,841.6 мянган төгрөгийн аж ахуйн материал, 3,145.0 мянган төгрөгийн түлш шатлах тослох материал, 329,009.3 мянган төгрөгийн бусад хангамжийн материал байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн төсвөөс хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтаар авто тээврийн хэрэгсэл 49,995.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 65,432.3 мянган төгрөг, тавилга эд хогшил 1,320.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө данснаас акталсан 21.260,8 мянган төгрөгийн дүнгээр буурсан байна.

Биет бус хөрөнгөд өссөн буурсан асуудал байхгүй байна.

Өр төлбөр байхгүй байна.



Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,398,001.2 мянган төгрөг болж 50,338.9 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 2,121,712.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2,121,712.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,121,712.6 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас 59,453.8 мянган нэмэлт санхүүжилтийг шилжүүлсэн байна.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 34,648.4 мянга төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардалд 25300.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 19 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 19 эрсдэл тодорхойлж нийт 19 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 45,738.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 6,575.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 39,162.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар дараах 45,738.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 45,738.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Номин тав трейд ХХК-с 1,741.5 мянган төгрөг, Бүжин шарга ХХК-с 4,833.9 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн цахим төлбөрийн баримт дахь бараа материалын зориулалт нэр төрөл нь харилцахын болон нярвын орлогын бүртгэл, гүйлгээнд хавсаргасан анхан шатны баримтаас зөрүүтэй байна. Бараа материалыг анхан шатны баримтаас зөрүүтэйгээр бэлтгэн, зориулалт бусаар зарцуулсан нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант хугацаанд хийсэн нийт 6,439.6 мянган төгрөгийн шатахууны худалдан авалтын Е баримтыг хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай



хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.5 дахь хэсэгт “... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэсэн заалтад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Сургуулийн хүүхдийн хоолны материал бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг мөрдөж ажиллаагүй, тендерийн баримт бичигт заагдаагүй 21,973.1 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйл “Худалдан авах гэрээнд нэмэлт, өөрчлөлт хийхийг хориглох” хэсгийн 41.1.2 дахь заалтад “энэ хуулийн 40.4-т зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөх” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. 3. Аж ахуйн хангамжийн материалд үндсэн хөрөнгийн шинж чанартай 10,000.0 мянган төгрөгийн ширээ сандал, 750.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж байна. Энэ нь санхүүгийн тайлангийн тодруулга, үнэлгээ, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Дорнод аймаг дахь Хэрлэн сумын ерөнхий боловсролын лаборатори Хан-уул цогцолбор сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 143 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэмжлэл авсан тул төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.



2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорнод аймаг дахь Хэрлэн сумын ерөнхий боловсролын лаборатори Хан-уул цогцолбор сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймаг дахь Хэрлэн сумын ерөнхий боловсролын лаборатори Хан-уул цогцолбор сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	181 056 015,21	285 440 654,34
35	БАРАА МАТЕРИАЛ	181 056 015,21	285 440 654,34
351	Түүхий эд материал	5 508 719,34	49 444 782,66
35110	Тусгай зориулалттай материал	5 508 719,34	49 444 782,66
354	Хангамжийн материал	175 547 295,87	235 995 871,68
35420	Аж ахуйн материал	00,00	3 841 600,00
35440	Түлш, шатах тослох материал	00,00	3 145 000,00
35470	Бусад хангамжийн материал	175 547 295,87	229 009 271,68
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7 167 960 220,00	7 092 657 221,49
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7 167 960 220,00	7 092 657 221,49
392	Биет хөрөнгө	5 515 289 220,00	5 439 986 221,49
39201	Барилга, байгууламж, орон сууц	5 324 289 151,43	5 324 289 151,43
39202	Хуримтлагдсан элэгдэл	-40 598 073,33	-132 018 989,13
39203	Авто-тээврийн хэрэгсэл	00,00	49 995 000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	00,00	-520 781,25
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	398 986 962,55	464 419 291,55
39206	Хуримтлагдсан элэгдэл	-310 597 632,73	-373 537 580,70
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	162 557 062,20	163 877 062,20
39208	Хуримтлагдсан элэгдэл	-55 317 848,44	-71 000 732,61
39214	Бусад үндсэн хөрөнгө	14 700 000,00	14 700 000,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00,00	-225 000,00
39217	Ном	21 269 598,32	8 800,00
393	Биет бус хөрөнгө	1 652 671 000,00	1 652 671 000,00
39301	Програм хангамж	815 000,00	815 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-815 000,00	-815 000,00
39303	Бусад биет бус хөрөнгө	1 652 671 000,00	1 652 671 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7 349 016 235,21	7 378 097 875,83
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7 349 016 235,21	7 378 097 875,83
51	Засгийн газрын хувь оролцоо	7 349 016 235,21	7 378 097 875,83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2 344 691 476,38	2 344 691 476,38
51101	Өмч: - төрийн	2 344 691 476,38	2 344 691 476,38
512	Хуримтлагдсан үр дүн	2 683 203 655,40	2 712 285 296,02
51210	Өмнөх үеийн үр дүн	2 683 203 655,40	2 661 942 857,08
51220	Тайлант үеийн үр дүн	00,00	50 342 438,94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2 321 121 103,43	2 321 121 103,43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7 349 016 235,21	7 378 097 875,83



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	2 022 394 852,94	2 366 345 768,13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	177 608 652,94	179 668 948,13
120	Нийтлэг татварын бус орлого	175 808 652,94	62 921 619,13
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	175 808 652,94	62 921 619,13
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	175 808 652,94	62 921 619,13
121	Хөрөнгийн орлого	1 800 000,00	116 747 329,00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	1 800 000,00	116 747 329,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	35 326 300,00	181 148 820,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1 809 459 900,00	2 005 528 000,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35 326 300,00	59 948 820,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00,00	4 000 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35 326 300,00	55 453 820,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00,00	495 000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00,00	121 200 000,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00,00	121 200 000,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2 101 183 986,34	2 316 003 329,19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2 101 183 986,34	2 316 003 329,19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2 008 848 103,32	2 239 437 069,95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1 298 669 584,00	1 586 288 618,96
210101	Үндсэн цалин	1 078 786 109,00	1 035 286 119,48
210102	Нэмэгдэл	139 500 686,00	401 739 000,00
210104	Урамшуулал	69 222 789,00	149 263 499,48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156 318 448,84	198 287 600,00
210201	Тэтгэврийн даатгал	101 043 330,15	135 599 232,74
210202	Тэтгэмжийн даатгал	10 399 429,64	13 939 301,13
210203	ҮОМШӨ-ний даатгал	13 751 912,82	14 616 826,40
210204	Ажилгүйдлийн даатгал	5 398 833,11	3 102 967,24
210205	Эрүүл мэндийн даатгал	25 724 943,12	31 029 272,49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102 540 259,00	103 440 713,80
210301	Гэрэл, цахилгаан	32 135 659,00	34 979 963,00
210302	Түлш, халаалт	60 056 793,00	56 741 838,80
210303	Цэвэр, бохир ус	10 347 807,00	11 718 912,00
2104	Хангамж, бараа материалын зардал	90 347 100,00	52 968 000,00
210401	Бичиг хэрэг	3 529 300,00	33 810 000,00
210402	Тээвэр, шатахуун	5 550 000,00	6 439 600,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3 455 000,00	4 074 000,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00,00	1 000 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	74 609 800,00	7 644 400,00
2105	Нормативт зардал	87 128 776,00	84 386 100,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1 536 600,00	2 495 000,00
210502	Хоол, хүнс	79 524 076,00	75 397 000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6 068 100,00	6 494 100,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43 325 000,00	14 723 000,00
210604	Урсгал засвар	43 325 000,00	14 723 000,00
2107	Томилолт, зочны зардал	1 120 000,00	4 335 000,00
210702	Дотоод албан томилолт	1 120 000,00	4 335 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4 291 300,00	3 972 500,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4 111 300,00	3 972 500,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	225 107 635,48	191 035 537,19
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19 954 000,00	20 246 008,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	202 646 635,48	170 789 529,19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92 335 883,02	76 566 259,24
2132	Бусад урсгал шилжүүлэг	92 313 612,00	71 699 000,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	72 060 412,00	71 699 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22 271,02	4 867 259,24
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22 271,02	4 867 259,24
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-78 789 133,40	50 342 438,94



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1 844 786 200,00	2 186 676 820,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1 844 786 200,00	2 186 676 820,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1 809 459 900,00	2 005 528 000,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35 326 300,00	59 948 820,00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00,00	4 000 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35 326 300,00	55 453 820,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00,00	495 000,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00,00	121 200 000,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00,00	121 200 000,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1 815 886 200,00	2 186 676 820,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 815 886 200,00	2 186 676 820,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1 723 550 316,98	2 110 110 560,76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1 303 140 900,00	1 586 288 618,96
210101	Үндсэн цалин	1 009 219 532,00	1 035 286 119,48
210102	Нэмэгдэл	196 269 900,00	401 739 000,00
210104	Урамшуулал	84 631 468,00	149 263 499,48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156 355 688,98	198 287 600,00
210201	Тэтгэврийн даатгал	100 530 704,29	135 599 232,74
210202	Тэтгэмжийн даатгал	11 172 893,64	13 939 301,13
210203	ҮОМШӨ-ний даатгал	13 567 281,82	14 616 826,40
210204	Ажилгүйдлийн даатгал	4 708 312,11	3 102 967,24
210205	Эрүүл мэндийн даатгал	26 376 497,12	31 029 272,49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102 572 952,00	106 585 713,80
210301	Гэрэл, цахилгаан	32 135 659,00	34 979 963,00
210302	Түлш, халаалт	60 056 793,00	59 886 838,80
210303	Цэвэр, бохир ус	10 380 500,00	11 718 912,00
2104	Хангамж, бараа материалын зардал	30 582 400,00	61 232 348,00
210401	Бичиг хэрэг	3 999 400,00	33 810 000,00
210402	Тээвэр, шатахуун	5 550 000,00	6 439 600,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3 530 000,00	4 074 000,00
210404	Ном, хэвлэл	4 203 000,00	5 190 748,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00,00	1 786 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13 300 000,00	9 932 000,00
2105	Нормативт зардал	87 128 776,00	89 148 100,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1 536 600,00	2 495 000,00
210502	Хоол, хүнс	79 524 076,00	75 397 000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6 068 100,00	11 256 100,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14 425 000,00	10 000 000,00
210604	Урсгал засвар	14 425 000,00	10 000 000,00
2107	Томилолт, зочны зардал	1 120 000,00	4 335 000,00
210702	Дотоод албан томилолт	1 120 000,00	4 335 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4 291 300,00	4 974 100,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4 111 300,00	4 974 100,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23 933 300,00	49 259 080,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2 507 000,00	2 507 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21 426 300,00	46 752 080,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92 335 883,02	76 566 259,24
2132	Бусад урсгал шилжүүлэг	92 313 612,00	71 699 000,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	72 060 412,00	71 699 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22 271,02	4 867 259,24
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22 271,02	4 867 259,24
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00,00	00,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00,00	00,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00,00	00,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00,00	00,00



4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	692 020 476,38	3 443 087,00	3 074 529 534,90	3 769 993 098,28
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	88 973 244,00	88 973 244,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	692 020 476,38	3 443 087,00	3 163 502 778,90	3 858 966 342,28
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00,00	00,00	00,00	00,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00,00	00,00	00,00	00,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00
C07	Тайлант үеийн үр дүн	1 652 671 000,00	00,00	-481 653 034,08	1 171 017 965,92
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2 344 691 476,38	2 321 121 103,43	2 683 203 655,40	7 349 016 235,21
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2 344 691 476,38	2 321 121 103,43	2 683 203 655,40	7 349 016 235,21
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00,00	00,00	-21 260 798,32	-21 260 798,32
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2 344 691 476,38	2 321 121 103,43	2 661 942 857,08	7 327 755 436,89
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00,00	00,00	00,00	00,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00,00	00,00	00,00	00,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00,00	00,00	00,00	00,00
D08	Тайлант үеийн үр дүн	00,00	00,00	50 342 438,94	50 342 438,94
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2 344 691 476,38	2 321 121 103,43	2 712 285 296,02	7 378 097 875,83



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2 121 712 600,00	2 121 860 740,76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2 121 712 600,00	2 121 860 740,76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2 055 029 000,00	2 050 161 740,76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1 586 299 600,00	1 586 288 618,96
210101	Үндсэн цалин	1 035 297 100,00	1 035 286 119,48
210102	Нэмэгдэл	401 739 000,00	401 739 000,00
210104	Урамшуулал	149 263 500,00	149 263 499,48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	198 287 600,00	198 287 600,00
210201	Тэтгэврийн даатгал	134 835 500,00	135 599 232,74
210202	Тэтгэмжийн даатгал	15 863 000,00	13 939 301,13
210203	ҮОМШӨ-ний даатгал	12 690 400,00	14 616 826,40
210204	Ажилгүйдлийн даатгал	3 172 600,00	3 102 967,24
210205	Эрүүл мэндийн даатгал	31 726 100,00	31 029 272,49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111 200 000,00	106 585 713,80
210301	Гэрэл, цахилгаан	33 600 000,00	34 979 963,00
210302	Түлш, халаалт	60 000 000,00	59 886 838,80
210303	Цэвэр, бохир ус	17 600 000,00	11 718 912,00
2104	Хангамж, бараа материалын зардал	26 768 600,00	26 760 028,00
210401	Бичиг хэрэг	5 451 800,00	5 451 800,00
210402	Тээвэр, шатахуун	5 439 600,00	5 439 600,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4 860 000,00	4 074 000,00
210404	Ном, хэвлэл	2 407 200,00	2 398 628,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1 000 000,00	1 786 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7 610 000,00	7 610 000,00
2105	Нормативт зардал	89 153 100,00	89 148 100,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2 500 000,00	2 495 000,00
210502	Хоол, хүнс	75 397 000,00	75 397 000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11 256 100,00	11 256 100,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10 000 000,00	10 000 000,00
210604	Урсгал засвар	10 000 000,00	10 000 000,00
2107	Томилолт, зочны зардал	4 335 000,00	4 335 000,00
210702	Дотоод албан томилолт	4 335 000,00	4 335 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4 978 000,00	4 798 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4 798 000,00	4 798 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180 000,00	00,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24007100,00	23958680,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2 507 000,00	2 507 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21 500 100,00	21 451 680,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66683600,00	71699000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	66 683 600,00	71 699 000,00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	66 683 600,00	71 699 000,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2 126 728 000,00	2 126 728 000,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2 005 528 000,00	2 005 528 000,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2 005 528 000,00	2 005 528 000,00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	121 200 000,00	121 200 000,00
132001	Орон нутгийн төсвөөс	121 200 000,00	121 200 000,00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	141,00	141,00
620001	Удирдах ажилтан	01,00	01,00
620002	Гүйцэтгэх ажилтан	118,00	118,00
620003	Үйлчлэх ажилтан	22,00	22,00